



МОНГОЛ УЛСЫН  
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН  
ТУШААЛ

2026 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

Батлан хамгаалахын шинжлэх ухаан,  
технологи, инновацын бүтээлийг эргэлтэд  
оруулах журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.13 дахь заалт, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.5, 13.2.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн 2026 оны хоёрдугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Батлан хамгаалахын шинжлэх ухаан, технологи, инновацын бүтээлийг эргэлтэд оруулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэхүү журмыг батлагдсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг яамны Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөл (Д.Баасандамба), Зэвсэгт хүчний Жанжин штаб (дэслэгч генерал С.Ганбямба), яамны харьяа байгууллагын дарга (захирал) нарт үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Батлан хамгаалахын сайдын 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/48 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (дэд хурандаа Ж.Эрдэнэсайхан)-т даалгасугай.

САЙД

Д.БАТЛУТ

1326100053

9. *Chlorophyll*

ॐ नमो भगवते वासुदेवाय

[illegible]

3. 02 יוני 2025 עד לסיום הפרויקט, יתקיימו שני סדנאות (workshops) ופעילות חינוכית נוספת.

[illegible][illegible][illegible]

2026 Jan 8  
Feb 7  
Mar 2

$$\frac{1}{m_2}$$

## စာအုပ်အမျိုးအမည်

Батлан хамгаалахын сайдын 2026 оны  
4 дугаар сарын 4 ны өдрийн  
А/33 дугаар тушаалын хавсралт

## БАТЛАН ХАМГААЛАХЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫН БҮТЭЭЛИЙГ ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Журмын зорилго нь аюулгүй байдал, батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх, чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн бүтээлийг шалгаруулах, зохиогч, бүтээгчийг шагнаж, урамшуулах, оюуны өмчийг эргэлтэд оруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмыг хэрэгжүүлэхдээ "Шинжлэх ухаан, технологийн тухай", "Патентын тухай", "Оюуны өмчийн тухай", "Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай" хуулиуд болон шинжлэх ухаан, технологи, инновацтай холбогдох бусад эрх зүйн баримт бичгүүдийг дагаж мөрдөнө.

1.3. Энэ журамд дурдагдсан инновацын бүтээгдэхүүн<sup>1</sup>, зохиогч/бүтээгч<sup>2</sup>, шинжлэх ухаан, технологийн төсөл<sup>3</sup>, захиалагч<sup>4</sup>, оюуны өмч<sup>5</sup>, ашигтай загвар<sup>6</sup>, шинэ бүтээл<sup>7</sup>, роялти<sup>8</sup>, лицензийн төлбөр<sup>9</sup>, худалдан авах ажиллагаа<sup>10</sup> гэсэн нэр томъёог Инновацын тухай хууль, Патентын тухай хууль, Технологи дамжуулах тухай хууль, Оюуны өмчийн тухай хуулиудад зааснаар тус тус ойлгоно.

1.4. Журам нь Батлан хамгаалах яамны харьяа байгууллага, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбар, төр, иргэн, хувийн хэвшлийн байгууллага, зохион бүтээгч, инноваторуудад хамаарна.

<sup>1</sup> "Инновацын тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4."инновацын бүтээгдэхүүн" гэж энэ хуулиар тогтоосон шаардлага, нөхцөлийг хангасан, зах зээл дээрх ижил төстэй бүтээгдэхүүн, үйлчилгээнээс техник, эдийн засгийн үзүүлэлт, шинжлэх ухааны багтаамж, нэмүү өртөг бий болгох болон өрсөлдөх чадвараар илүү инновацын үйл ажиллагааны үр дүнг;

<sup>2</sup> "Патентын тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8."зохион бүтээгч" гэж шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар зохион бүтээсэн хувь хүнийг;

<sup>3</sup> "Патентын тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.17."шинэ бүтээл" гэж байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон бүтээгдэхүүн, үйлдвэрлэх арга, ажиллагаанд хамаарах техникийн шийдлийг.

<sup>4</sup> Засгийн газрын 2015 оны тогтоолын хавсралтаар батлагдсан "Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, эзэмшүүлэх журам"-ын 2.1.4. "захиалагч" гэж улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэх эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг захиалсан төсвийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийг;

<sup>5</sup> "Оюуны өмчийн тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1."оюуны өмч" гэж оюуны бүтээлч үйл ажиллагааны үр дүнд бий болсон зохиогчийн эрхийн бүтээл, зохиогчийн эрхэд хамаарах эрхийн объект болон аж үйлдвэрийн өмчийг;

<sup>6</sup> "Патентын тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3."ашигтай загвар" гэж багаж, хэрэгсэл, түүнтэй адилтгах бүтээгдэхүүний бүрэлдэхүүнд хамаарах техникийн шийдлийг;

<sup>7</sup> "Патентын тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.17."шинэ бүтээл" гэж байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон бүтээгдэхүүн, үйлдвэрлэх арга, ажиллагаанд хамаарах техникийн шийдлийг.

<sup>8</sup> "Инновацын тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.10."роялти" гэж оюуны өмчийг лицензийн гэрээгээр ашиглан олсон ашгаас лиценз түрээслүүлэгчид ногдох хувь хэмжээг;

<sup>9</sup> "Технологи дамжуулах тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.Лицензийн төлбөр нь нэг удаагийн, эсхүл тухайн технологи ашигласнаас олох ашгийн тодорхой хувь хэмжээгээр тогтоосон байнгын шимтгэл, эсхүл эдгээрийг хосолсон хэлбэртэй байж болно.

<sup>10</sup> "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.23."худалдан авах ажиллагаа" гэж бараа худалдан авах, түрээслэх, ажил гүйцэтгүүлэх, үйлчилгээ авах ажиллагааг төлөвлөх, тендер шалгаруулалтын аргыг сонгох, үнэлгээний хороо байгуулах, тендер шалгаруулалт зохион байгуулах, тендер шалгаруулалтын үр дүнд байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, мэдээлэх ажиллагааг;

1.5. Энэ журмыг хэрэгжүүлэхэд дараах нийтлэг зарчмыг баримтална:

- 1.5.1.хууль дээдлэх;
- 1.5.2.ил тод, нээлттэй байх;
- 1.5.3.зохиогч, бүтээгчдийн оролцоог хангах;
- 1.5.4.ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- 1.5.5.судалгаанд үндэслэгдсэн байх;
- 1.5.6.бодит үр дүнд тулгуурласан байх.

#### Хоёр. Бүтээлийг сонгон шалгаруулах

2.1. "Шинжлэх ухаан, технологи, инновацын бүтээл"-ийг дараах төрлөөр жил бүр сонгон шалгаруулна. Үүнд:

2.1.1.хэвлэмэл бүтээл:

- 2.1.1.1.аюулгүй байдал судлал;
- 2.1.1.2.батлан хамгаалах судлал;
- 2.1.1.3.цэргийн шинжлэх ухаан;
- 2.1.1.4.цэргийн түүх.

2.1.2.цэргийн зэвсэглэл, техник, технологи, инновац, программ хангамжийн бүтээл:

- 2.1.2.1.цэргийн зэвсэглэл, техник;
- 2.1.2.2.цэргийн технологи, инновацын дэвшил;
- 2.1.2.3.шинэ бүтээл, оновчтой санал;
- 2.1.2.4.хиймэл оюун, программ хангамж;
- 2.1.2.5.залуу судлаачийн бүтээл.

2.2. Бүтээлийн хэвлэмэл төрөл тус бүрээр "Тэргүүн", "Дэд", "Гутгаар" байр эзлүүлнэ.

2.3. Энэхүү журмын 2.1-д заасан төрлөөр сүүлийн 3 жилийн дотор туурвисан (зохион бүтээсэн) бүтээлийг нэр дэвшүүлж болох бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.3.1.шинэ бүтээл, ашигтай загварын патент, зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан байх;

2.3.2.Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний язгуур эрх ашигт харшлахгүй байх;

2.3.3.бүтээл нь аюулгүй байдал, батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэхэд чиглэсэн, цэргийн хэрэгт нэвтрүүлэх, ашиглах, цаашид төсөл, хөтөлбөр болгон хэрэгжүүлэх, нийгэм, эдийн засгийн бодит тооцоо, судалгаанд үндэслэгдсэн байх;

2.3.4.тухайн бүтээлийг хэвлэн нийтлүүлж, сургалт, судалгааны эргэлтэд оруулсан, зохион бүтээж, туршилт хийсэн байх;

2.3.5.орчин үеийн дэвшилтэд технологи, инновацын шийдлийг агуулсан, хиймэл оюунд суурилсан байх;

2.3.6.цэргийн зэвсэглэл, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах, дахин ашиглах боломжийг эрэлхийлсэн байх;

2.3.7.хамтын бүтээлийн зохиогчийн хамтлаг нь 3 хүнээс хэтрэхгүй байх;

2.3.8.хэвлэмэл бүтээлийг үндэсний цахим сангийн хуулбарлалт шалгах программд шалгуулж, хуулбарлалтын түвшин 30 хувиас хэтрэхгүй байх.

2.4. Нэр дэвшүүлсэн бүтээлийг дараах тохиолдолд шалгаруулалтад оролцуулахгүй. Үүнд:

2.4.1.холбогдох баримт бичгийг дутуу болон хуурамчаар бүрдүүлсэн;

2.4.2.энэ журмын 2.10-т заасан хугацаанд ирүүлээгүй;

2.4.3.улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмч, судалгааны ажлын тайлан, орчуулсан ном, сурах бичиг, гарын авлага, дахин хэвлэсэн материал болон өмнө нь нэр дэвшсэн бүтээл;

2.4.4.шинэ бүтээлийг нийтлэх, эсхүл эдийн засгийн эргэлтэд оруулах нь нийгмийн дэг журам, зан суртахуун, хүн, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд харш бол<sup>11</sup>;

2.4.5.улс, салбарын хэмжээний албан ёсны шалгаруулалтад шалгарч, шагнал хүртсэн бүтээлийг хүлээн авахгүй.

2.5. Шалгаруулалтад зохиогч, бүтээгч нь хэд хэдэн төрөлд бүтээл ирүүлж болно.

2.6. Нэр дэвшүүлсэн бүтээлд дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

2.6.1.шалгаруулалтад оролцуулах бүтээл (хэвлэмэл бүтээлийн эх хувь, зохион бүтээгдсэн бие анги, программ хангамж);

2.6.2.бүтээлийн товч танилцуулга (үүнд: зохиогч /хамтран зохиогч/-ийн нэр, аюулгүй байдал, батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухааны онол, аргазүй болон зэвсэглэл, цэргийн техник, технологи, инновацын шийдэлд оруулж буй хувь нэмэр, ач холбогдол, шинэлэг тал, үр ашиг, зарцуулсан зардлын тооцоо);

2.6.3.зохион бүтээгдсэн биет бүтээлийн хийц, эдлэл бүрийн бат бэхийн болон инженер, механикийн тооцоолол, техникийн зураг, үйлдвэрлэх технологийн карт, нэгийг болон олноор үйлдвэрлэх зардлын тооцоо, харьцуулсан судалгаа;

2.6.4.тухайн бүтээлийг шүүн хэлэлцээд шалгаруулалтад нэр дэвшүүлэхээр шийдвэрлэсэн тухай хурлын шийдвэр, тэмдэглэл;

2.6.5.бүтээлийг цэргийн хэрэгт, үйлдвэрлэлд туршиж, нэвтрүүлсэн, эсхүл нэвтрүүлэх боломжтойг тодорхойлсон (сургалт, судалгааны эргэлтэд оруулсан, цаашид үр дүнг ашиглах, хөгжүүлэх, шинэчлэн сайжруулах боломж, эдийн засгийн тооцоо, хүрэх үр дүн) тухай байгууллагын тодорхойлолт;

2.6.6.бүтээлд мэргэжлийн 2-оос доошгүй эрдэмтний өгсөн дүгнэлт, биет бүтээлийн бат бэхийн болон инженер, механикийн тооцооллыг баталсан, техникийн зураг, бүдүүвч, үйлдвэрийн технологийн картыг хянасан, материалын сонголтод хийсэн баталгаажилт, шүүмж;

2.6.7.биет бүтээлийг цаашид үйлдвэрлэх, зэвсэглэлд нийлүүлэх, загвар, зориулалтыг өөрчлөх, нэмэлт тоноглол хийхийг зөвшөөрсөн тухай мэргэжлийн газар, хэлтсийн тодорхойлолт;

2.6.8.шалгаруулалтад ирүүлж буй бүтээлийн ашигтай загвар (патент)-ын болон зохиогчийн эрхийн гэрчилгээ;

2.6.9.нууцын зэрэгтэй бүтээлийг нэр дэвшүүлсэн тохиолдолд төслийн багийг томилсон, даалгаваржуулсан тухай байгууллагын даргын тушаал, нууцын гэрээний хэрэгжилт, дүгнэлтийг нууцын журамд нийцүүлэх ба патент авахаас бусад бүрдүүлбэр.

---

<sup>11</sup> Патентын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3.4.шинэ бүтээлийг нийтлэх, эсхүл эдийн засгийн эргэлтэд оруулах нь нийгмийн дэг журам, зан суртахуун, хүн, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд харш бол;

2.7. Шалгаруулалтад нэр дэвшүүлж байгаа хэвлэмэл бүтээлийг гурван хувь, программ хангамжийг CD, DVD хэлбэрээр хуулбарлан ирүүлэх ба бүтээлийн нэг хувийг шалгаруулалтын баримтад хавсаргана.

2.8. Шинжлэх ухаан, технологи, инновацын бүтээлийг сонгон шалгаруулах тухай зарыг шалгаруулалтаас 90 хоногийн өмнө хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар нээлттэй зарлана.

2.9. Нэр дэвшүүлсэн бүтээлийн холбогдох материалыг тухайн жилийн 09 дүгээр сард багтааж, яамны Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөлд ирүүлнэ.

2.10. Шалгаруулалтыг 2 шаттай зохион байгуулна:

2.10.1.нэгдүгээр шат: Хэвлэмэл бүтээлийг “Цэргийн шинжлэх ухаан, аюулгүй байдал, батлан хамгаалах судлал”-ын салбар зөвлөл, Цэргийн зэвсэглэл, техник, технологи, инновац, программ хангамжийн бүтээлийг “Техник, технологи, инновац”-ын салбар зөвлөл жил бүрийн 10 дугаар сард багтаан шалгаруулна;

2.10.2.хоёрдугаар шат: Салбар зөвлөлүүд шалгаруулсан бүтээлүүдийг яамны Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөл жил бүрийн 11 дүгээр сард багтаан хэлэлцэн, эцсийн байдлаар шалгаруулна.

2.11. Шалгаруулалтад ирүүлсэн бүтээлээс хамааран салбар зөвлөлүүдийг 2 хүртэлх эрдэмтэн, мэргэжилтэн, албан тушаалтнаар өргөтгөж болно. Тухайн эрдэмтэн, мэргэжилтнийг салбар зөвлөлүүд сонгож оролцуулна. Салбар зөвлөлийн дарга, үндсэн болон өргөтгөсөн гишүүний бүтээл нэр дэвшсэн тохиолдолд санал өгөх эрхгүй байна.

Гурав. Зохиогч, бүтээгчийг шагнаж, урамшуулах

3.1. Шинжлэх ухаан, технологи, инновацын бүтээлийн сонгон шалгаруулалтын хэвлэмэл бүтээлийн төрөл тус бүрээр “Тэргүүн”, “Дэд”, “Гутгаар” байр эзлүүлж, шалгарсан бүтээлийн зохиогч, бүтээгчдэд дараах төрлөөр урамшуулал олгоно.

3.1.1.хэвлэмэл бүтээлийн төрөлд:

3.1.1.1.“Тэргүүн” байрт - 4,000,000 төгрөг;

3.1.1.2.“Дэд” байрт - 3,000,000 төгрөг;

3.1.1.3.“Гутгаар” байр - 2,000,000 төгрөг.

3.2. Цэргийн зэвсэглэл, техник, технологи, инновац, программ хангамжийн төрөлд шалгарсан болон нэр дэвшсэн бүтээл нь батлан хамгаалах эрх ашигт нийцсэн, импортын бүтээгдэхүүнийг орлох, эдийн засагт бодит хэмнэлт бий болгосон нь баталгаажсан тохиолдолд дараах урамшууллыг олгоно.

3.2.1.зохиогч, бүтээгчийн өөрийн зардлаар бүтээсэн оюуны өмч нь цаашид цэргийн хэрэгт ашиглах, олноор үйлдвэрлэж, эдийн засгийн эргэлтэд оруулах боломжтой тохиолдолд жилд 3 оюуны өмчийн анхдагч зохиогч, бүтээгч, төслийн багийг 100,000,000 хүртэлх төгрөгөөр урамшуулна;

3.2.2.зохиогч, бүтээгчийн бүтээл (технологич) нь оюуны өмчөөр баталгаажаагүй ч цэргийн хэрэгт ашиглах, цаашид хөгжүүлэх, олноор үйлдвэрлэх боломжтой тохиолдолд жилд 2 зохиогч, бүтээгчийг 40,000,000 хүртэлх төгрөгөөр урамшуулна;

3.2.3.зохиогч, бүтээгчийн өөрийн зардлаар бүтээсэн бүтээл (технологи) нь цаашид оюуны өмчөөр баталгаажих, цэргийн хэрэгт ашиглах, олноор үйлдвэрлэж, эдийн засгийн эргэлтэд оруулах боломжтой тохиолдолд жилд 3 хүртэлх бүтээлийг салбарын захиалга, төсвөөр судалгаа, хөгжүүлэлтийн төсөл болгон хэрэгжүүлж, зохиогч, бүтээгч, төслийн багт гэрээт ажилчдын хөлс олгоно.

Төслийн баг 4 хүртэлх хүнтэй байх ба гэрээт ажилчдын хөлсний хэмжээг судалгаа, хөгжүүлэлтийн ажлын гэрээгээр тогтоож, олгоно.

**Дөрөв. Бүтээлийг эзэмших, ашиглах, худалдан авах,  
эргэлтэд оруулах**

4.1. Шинжлэх ухаан, технологи, инновацын бүтээл (шинэ бүтээл, технологи, инновац)-ийг ашиглах, худалдан авах, эргэлтэд оруулах асуудлыг холбогдох эрх зүйн баримт бичгийн хүрээнд зохицуулна.

4.2. Зохиогч, бүтээгчийн оюуны өмчийг ашиглах:

4.2.1.энэ журмын 3.2.1-т заасан оюуны өмчийг батлан хамгаалах салбар болон бусад иргэн, хуулийн этгээд эзэмшиж, ашиглах тохиолдолд лицензийн гэрээ байгуулах бөгөөд Инновацын тухай хуулийн 27.5<sup>12</sup>-д зааснаар зохиогч, бүтээгчид роялти төлнө.

4.2.2.энэ журмын 3.2.1-т заасан оюуны өмчийн эзэмшигч нь эрдэм шинжилгээний байгууллага байх тохиолдолд бүтээлийг ашигласнаас олсон орлогоос Инновацын тухай хуулийн 27.10<sup>13</sup> зааснаар зохиогч, бүтээгчид роялтигийн хувь олгох бөгөөд үлдсэн орлогыг зөвхөн инновацын судалгаа, сургалтад зарцуулна.

4.2.3.энэ журмын 3.2.3-т заасан бүтээлийг зах зээлд (иргэний салбарт) нийлүүлсэн тохиолдолд төвлөрүүлсэн нийт орлогоос зохиогч, бүтээгчид хувь олгох асуудлыг гэрээгээр шийдвэрлэнэ.

4.3. Зохиогч, бүтээгчийн оюуны өмчийг худалдан авах:

4.3.1.энэ журмын 3.2.1-т заасан оюуны өмч болон 3.2.2-т заасан батлан хамгаалах эрх ашигт нийцсэн, импортын бүтээгдэхүүнийг орлох, эдийн засагт бодит хэмнэлт бий болгосон нь баталгаажсан бүтээлийг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 3.3.1<sup>14</sup>, мөн хуулийн 10.8<sup>15</sup>-т заасныг тус тус үндэслэн худалдан авна.

Оюуны өмчийг худалдан авахад шаардлагатай төсвийг Батлан хамгаалахын сайдын багцад жил бүр тусган хэрэгжүүлнэ.

4.4. Зохиогч, бүтээгчийн бүтээлийг эргэлтэд оруулах:

<sup>12</sup> “Инновацын тухай” хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.Зохиогчийн анхдагч эрхийг уг оюуны өмчийг бий болгосон судлаач болон эрдэм шинжилгээний байгууллагаас бусад хуулийн этгээд лицензээр эзэмшсэн тохиолдолд тэдгээрт роялти төлнө;

<sup>13</sup> “Инновацын тухай” хуулийн 27 дугаар зүйлийн 27.10.Төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг эзэмшигч нь эрдэм шинжилгээний байгууллага байх тохиолдолд дараах үүргийг хүлээнэ:

<sup>14</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 3 дугаар зүйлийн 3.3.Энэ хууль бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой дараах харилцааг зохицуулахад хамаарахгүй: 3.3.1.хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авах ажиллагаа;

<sup>15</sup> “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.8.Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, хил хамгаалах, онцгой байдлын байгууллага, цагдаа, дотоодын цэрэг, хорих байгууллагын тусгай хэрэгцээний бараа, ажил, үйлчилгээг тухайн салбарын төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраар гүйцэтгүүлэх, эсхүл хорих байгууллагын өөрийн хэрэгцээний ажлыг холбогдох хуулийн дагуу гүйцэтгүүлэх нь үр ашигтай гэж захиалагч үзсэн бол нээлттэй тендер шалгаруулалтын аргыг хэрэглэхгүй байж болно.

4.4.1.энэ журмын 3.2.1-т заасан оюуны өмчийг олноор үйлдвэрлэж (хэвлэж) цэргийн хэрэгт ашиглах асуудлыг Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, үр дүнг ашиглалтад шилжүүлнэ.

4.4.2.энэ журмын 3.2.2-т заасан бүтээл (технологи)-ийг олноор үйлдвэрлэж, цэргийн хэрэгт ашиглах асуудлыг Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, үр дүн нь ашиглалтад шилжсэний дараа эргэлтэд оруулна.

4.4.3.энэ журмын 3.2.3-т заасан бүтээл (технологи)-ийг салбарын захиалгат судалгаа, хөгжүүлэлтийн төсөл болгон хэрэгжүүлэх асуудлыг яамны Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөл хэлэлцэн шийдвэрлэж, үр дүн нь оюуны өмчөөр баталгаажиж, ашиглалтад шилжсэний дараа эргэлтэд оруулна.

4.5. Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа хуульд өөрөөр заагаагүй бол талууд оюуны өмчийн үнэлгээг харилцан тохиролцож тогтоож болно<sup>16</sup>.

4.6. Энэ журмын 4.4.3-т заасан салбарын захиалгат судалгаа, хөгжүүлэлтийн төслийг Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн төсөвт жил бүр тусган санхүүжүүлнэ.

4.7. Энэ журмын 4 дэх хэсэгт заасан бүтээлийг ашиглах, худалдан авах, эргэлтэд оруулах асуудлыг яамны Шинжлэх ухаан, технологи, инновацын зөвлөл хэлэлцэн, Батлан хамгаалахын сайдын зөвлөлд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

#### Тав. Бусад

5.1. Оюуны өмчид хамаарах эрхийн бүртгэл, баталгаажуулалт, хамгаалалт, ашиглалтыг Оюуны өмчийн тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ.

5.2. Зохиогч, бүтээгч нь бүтээлийн зохиогчийн эрхийн эзэн байхаас үл хамааран тухай бүтээлийн нэр хүндийн болон эдийн бус эрхээ хадгална.

5.3. Энэ журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой төсвийг Батлан хамгаалахын сайдын багцад жил бүр тусгана.

5.4. Оюуны өмч болон батлан хамгаалах эрх ашигт нийцсэн бүтээлийг худалдан авах асуудлыг яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар зохион байгуулна.

5.5. Энэ журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа зөрчил, маргааныг холбогдох хууль, эрх зүйн хүрээнд шийдвэрлэнэ.

---oOo---

---

<sup>16</sup> “Оюуны өмчийн тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахдаа хуульд өөрөөр заагаагүй бол талууд оюуны өмчийн үнэлгээг харилцан тохиролцож тогтоож болно.